



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/531

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ерөнхий сайдын 2025 оны 64 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Яам, харьяа байгууллагын хэмжээнд “Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ”-г хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бусад төрийн байгууллагууд болон төрийн бус байгууллагатай хамтран оролцоог ханган ажиллахыг Ажлын хэсгийн дарга Д.Очирбатад даалгасугай.

3. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд яамны газар, хэлтэс, харьяа байгууллагын дарга, захирал нар идэвх, санаачлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Янжмаа)-т даалгасугай.

САЙД

Ж.ЧИНБҮРЭН

141251807

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 09...
дугаар сарын 11... өдрийн А/331 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Д.Очирбат, Төрийн нарийн бичгийн
дарга

Гишүүд:

С.Эрдэнэтуяа, Төрийн захиргааны
удирдлагын газрын дарга;

Д.Отгонбаатар, Эрүүл мэндийн
даатгалын бодлого, зохицуулалтын
газрын дарга;

М.Наранпүрэв, Эмнэлгийн
тусламжийн бодлогын хэрэгжилтийн
газрын дарга;

Д.Баярболд, Нийгмийн эрүүл мэндийн
бодлогын хэрэгжилтийн газрын
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч;

Б.Янжмаа, Салбарын хяналт-
шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
газрын дарга;

Б.Туяа, Бодлого төлөвлөлтийн газрын
Салбарын хүний нөөцийн хөгжлийн
хэлтсийн дарга;

Б.Түмэннаст, Бодлого төлөвлөлтийн
газрын Эрүүл мэндийн инновац,
технологи, цахим хөгжлийн хэлтсийн
дарга;

Т.Болорчимэг, Санхүү, эдийн засгийн
бодлогын хэрэгжилтийн газрын
шинжээч;

А.Баярзаяа, Эмнэлгийн тусламжийн
бодлогын хэрэгжилтийн газрын
мэргэжилтэн;

Б.Цэрэн-Очир, Бодлого төлөвлөлтийн
газрын Эрүүл мэндийн инновац,

технологи, цахим хөгжлийн хэлтсийн
ахлах мэргэжилтэн;

Г.Түвшинбаяр, Төрийн захиргааны
удирдлагын газрын Хууль, эрх зүйн
асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн;

Г.Бямбасүрэн, Төрийн захиргааны
удирдлагын газрын мэргэжилтэн;

Б.Батцэцэг, Сайдын хэвлэл
мэдээллийн ажилтан;

Н.Эрдэнэбаяр, Эм, эмнэлгийн
хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын дарга;

М.Одгэрэл, Эрүүл мэндийн хөгжлийн
төвийн дарга ;

М.Нармандах, Эрүүл мэндийн
даатгалын ерөнхий газрын Тамгын
газрын дарга;

Ц.Батболд, Хавдар судлалын
үндэсний төвийн дарга;

Л.Бямбасүрэн, Улсын нэгдүгээр төв
эмнэлгийн захирал;

Ж.Отгонбаатар, Эх, хүүхдийн эрүүл
мэндийн үндэсний төвийн захирал;

Г.Ууганцэцэг, Сэтгэцийн эрүүл
мэндийн үндэсний төвийн дарга;

Д.Оюунбилэг, Эрүүл мэндийн яамны
дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс
зүйн хяналтын хорооны дарга
/Зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:

С.Энхжин, Салбарын хяналт-
шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
газрын ахлах шинжээч;

Ө.Энхмаа, Бодлого төлөвлөлтийн
газрын Салбарын хүний нөөцийн
хөгжлийн хэлтсийн шинжээч;

М.Хулан, Төрийн захиргааны
удирдлагын газрын Хууль, эрх зүйн
асуудал хариуцсан мэргэжилтэн.



“Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Ерөнхий сайдын захирамжийг эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах нэгж
Нэг. Мэдээллийн ил тод байдал, иргэний мэдэх эрхийг хангах			
1.1.	Засгийн газраас өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд иргэд, олон нийтийн саналыг заавал авах, нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулах (Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль, Цусны донорын тухай хууль)	2025 оны 09 дүгээр сар	ЭМДБЗГ ЭТБХГ
1.2.	Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсанд мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, мэдээллийг байршуулах, хяналт тавих журмыг шинэчлэн батлах	2025 оны 09 дүгээр сар	БТГ
1.3.	Яам, харьяа байгууллагын мэдээллийг Нээлттэй мэдээлэл shilen.gov.mn цахим санд бүрэн оруулах	2025 оны 09 дүгээр сар	БТГ
1.4.	Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журамд санал өгөх	2025 оны 09 дүгээр сар	СХШУДАГ
Хоёр. Төрийн албан дахь авлигыг бууруулах			
2.1.	Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагуудын хийж байгаа зөвлөх үйлчилгээний 2024-2025 оны гэрээнд дүн шинжилгээ хийх	2025 оны 09 дүгээр сар	СХШУДАГ СЭЗБХГ ТЗУГ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах нэгж
2.2.	Харьяа байгууллагуудын Хөдөлмөрийн дотоод журамд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх зохицуулалтыг нарийвчлан тусгуулах	2025 оны 09 дүгээр сар	Харьяа эрүүл мэндийн байгууллагууд
2.3.	Төрийн захиргааны албан хаагчдын гүйцэтгэлийн үр дүн, тайланг байгууллагын цахим хуудсанд бүрэн байршуулах	2025 оны 09 дүгээр сар	ТЗУГ
2.4.	Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, төрийн албан хаагчдын тоог бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх ажлыг эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх, хяналт тавих	2025 оны 09 дүгээр сар	БТГ СЭЗБХГ
2.5.	Эрүүл мэндийн байгууллагуудад авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр богино хэмжээний видео бичлэг хийж, түгээх	2025 оны 09 дүгээр сар	ТЗУГ ХСҮТ ЭХЭМҮТ УНТЭ
2.6.	Авлигын эсрэг хууль эсхүл Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал өгөх	2025 оны 09 дүгээр сар	ТЗУГ
Гурав. Бизнесийн орчин дахь авлигыг бууруулах			
3.1.	Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн журмыг шинэчлэн батлах	2025 оны 09 дүгээр сар	ЭТБХГ
3.2.	Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөл олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах	2025 оны 09 дүгээр сар	БТГ
3.3.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад тусгай зөвшөөрлийн нэгдсэн үзлэг зохион байгуулах	2025 оны 09 дүгээр сар	ЭМДЕГ ЭМДБЗГ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах нэгж
3.4.	Зөвшөөрлийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулах	2025 оны 09 дүгээр сар	ЭТБХГ БТГ
3.5.	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын тусгай зөвшөөрөл олголтын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн гүйцэтгэлийн хяналт хийх	2025 оны 09 дүгээр сар	СХШУДАГ
3.6.	Эрүүл мэндийн даатгалын сонгон шалгаруулалт, нэхэмжлэлийн ил тод байдлыг хангах	2025 оны 09 дүгээр сар	ЭМДЕГ ЭМДБЗГ
3.7.	Банкнаас хураагдсан хөрөнгийг худалдан борлуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх	2025 оны 09 дүгээр сар	ЭМДҮЗ-ийн Ажлын алба ЭМДЕГ ЭМДБЗГ
3.8.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлэгт байрлаж буй Call center дуудлагын үйл ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх талаар судлах	2025 оны 09 дүгээр сар	БТГ ЭТБХГ
Дөрөв. Ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сайжруулах			
4.1.	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны шийдвэрийн хэрэгжилтэд 3-аас доошгүй эрүүл мэндийн байгууллагад явцын хяналт, үнэлгээ хийх	2025 оны 09 дүгээр сар	БТГ ЭМЁЗХХ
4.2.	Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр богино видео бичлэг хийх	2025 оны 09 дүгээр сар	БТГ ЭМЁЗХХ ТЗУГ
4.3.	“Ёс зүйн болзошгүй зөрчлөөс ухамсартайгаар зайлсхийх, ёс зүйтэй шийдвэр гаргах нь” сэдвээр удирдах түвшний менежерүүдэд сургалт зохион байгуулах	2025 оны 09 дүгээр сар	БТГ ЭМЁЗХХ
4.4.	“Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлэх” аян зохион байгуулах	2025 оны 09 дүгээр сар	БТГ ЭМЁЗХХ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах нэгж
4.5.	Ёс зүйн тодорхойлолт олгох журмыг шинэчлэн баталж, ёс зүйн тодорхойлолтын лавлагааг цахимаар олгодог болох	2025 оны 09 дүгээр сар	БТГ ЭМЭЗХХ
Тав. Бусад			
5.1.	Иргэдээс Эрүүл мэндийн яаманд 2024 онд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлэх	2025 оны 09 дүгээр сар	СХШУДАГ
5.2.	Эрүүл мэндийн яам болон харьяа байгууллагуудад Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хяналт хийх	2025 оны 09 дүгээр сар	СХШУДАГ

---oOo---